



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

# МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Иргэдэд зориулсан гарын авлага

Улаанбаатар хот  
2005 он

DDC  
323.445  
M-949

Гарын авлагыг бэлтгэсэн:

Х.Наранжаргал

Ж.Туул

Д.Мөнхбүрэн

Зургийг бэлтгэсэн: С.Бямба

Хянан тохиолдуулсан: Б.Чимэд

Ж.Баярцэцэг

Нээлттэй Нийгэм Форумын зөвшөөрөлгүйгээр энэхүү номыг хэсэгчлэн  
буюу бүтнээр нь дахин хэвлэхийг хориглоно.

“СОЁМБО ПРИНТИНГ” ХХК-д хэвлэв.

ISBN 99929-9-108-9

## ИРГЭН ТАНЫГ ХӨТЛӨХИЙН УЧИР

Нээлттэй Нийгэм Форумаас иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдэд зориулсан цуврал хөтөч бэлтгэн гаргаж байгаа билээ. Энэхүү хөтөчийн нэг болох “МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ” гарын авлага нь та бүхний гар дээр очиж байна.

Мэдээллийн эрх чөлөө нь ардчилал, сайн засаглал, ил тод байдлын гол тулгуур нь бөгөөд авилгал, хүнд сурталтай тэмцэх чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

Энэхүү гарын авлага нь иргэд төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх, уг эрхээ хэрэгжүүлэх арга замын талаар иргэдэд чухал шаардлагатай, иж бүрэн мэдээллийг хялбар бөгөөд сонирхолтой хэлбэрээр хүргэж, энэ талаарх иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар нийгмийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм. Гарын авлагад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Үндсэн хууль, иргэдийн мэдээлэл олж эрхийг зохицуулсан бусад хууль эрх зүйн актуудыг багтаан оруулсан болно.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж уг гарын авлагыг бэлтгэн боловсруулсан Глоб Интернэшнл ТББ-ын хамт олонд талархалаа илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын захирал  
П.Эрдэнэжаргал

## ГАРЧИГ

1. Мэдээллийн эрх чөлөө гэж юу вэ?.....	5
2. Мэдээлэл ямар ач холбогдолтой вэ? .....	7
3. Би яагаад мэдээлэл олж авах эрхтэй вэ?.....	9
4. Шууд оролцоо гэж юу вэ?.....	15
5. Төлөөлөлтэй байх эрх гэж юу вэ?.....	17
6. Мэдээллийн чанартай үйлдэл хийх эрх гэж юу вэ?.....	21
7. Мэдэх эрх гэж юу вэ?.....	26
8. Би ямар аргаар мэдээлэл олж авах вэ?.....	27
9. Миний мэдээлэл олж авах эрхийг яаж хуульчилсан вэ?.....	29
10. Би ямар мэдээлэл олж авах эрхтэй вэ?.....	32
11. Манай улсад ямар мэдээллийг нууцалдаг вэ?.....	33
12. Төрийн нууцын тухай хуулиар ямар мэдээллийг нууцад хамааруулсан вэ?.....	34
13. Байгууллагын нууцад ямар мэдээлэл багтдаг вэ?.....	34
14. Би хувь хүний талаар хүссэн мэдээллээ олж авах эрхтэй юу?.....	36
15. Манай улсад мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах хууль байдаг уу?.....	39
16. Төрийн байгууллагад ямар мэдээлэл хадгалагддаг вэ?.....	40
17. Би байгууллагаас ямар аргаар мэдээлэл олж авах вэ?.....	41
18. Би байгууллагаас мэдээлэл олж авахын тулд хэнд хандах ёстой вэ?.....	42
19. Мэдээлэл авсныхаа төлөө би төлбөр төлөх үү?.....	43
20. Би мэдээлэл олж авах шалтгаанаа тайлбарлах ёстой юу?.....	43
21. Таны хүссэн мэдээллийг нууцад хамруулах өөр шалтгаан бий юу?...44	
22. Мэдээлэл өгөхөөс татгалзвал яах вэ?.....	45
23. Мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг хангах үндэслэл, журмыг тусгайлан хуульчлах шаардлагатай юу?.....	47
24. Мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээнд юу багтдаг вэ?.....	49
25. Мэдээллийн эрх чөлөөний тухай болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль хоёр ялгаатай юу?.....	51
26. Төр мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээдэг үү? .....	53
27. “Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал ба иргэдийн мэдээлэл олж авах эрх” сэдэвт судалгааны дүнгээс.....	54
28. Бусад орон дахь мэдээллийн эрх чөлөөний баталгаа.....	71

# 1. Мэдээллийн эрх чөлөө гэж юу вэ?

Ардчилсан нийгэмд мэдээлэл чөлөөтэй, ил тод байх гэсэн зарчим баримталдаг. Энэхүү зарчмыг хангахын тулд иргэд мэдээлэл хайх, олж авах, хүлээн авах, түгээх эрхтэй байх ёстой. Эдгээр эрхийг бүхэлд нь **мэдээллийн эрх чөлөө** гэнэ.



Дарангуйлагч дэглэмтэй нийгэмд улс орны амьдралын үнэн бодит байдлын тухай мэдээлэл хаалттай байдаг. Тэнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь засаг төрийн цагдан хяналтад (цензурт) байдаг. Иймд иргэд мэдээллийн тийм хэрэгслээр дамжуулсан хуурмаг мэдээллийг арга буюу хүлээн авдаг.

Тэгвэл ардчилсан, чөлөөт нийгэмд мэдээлэл бол хүчил төрөгч юм.

Мэдээлэл олж авах нь ардчилсан нийгэмд амьдарч буй хүн бүрийн үндсэн эрхийн нэг бөгөөд иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах нь ардчилсан төрийн үүрэг юм.



НҮБ-ын Ерөнхий Ассемблейн Анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоолоос:

*Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн.*

## 2. Мэдээлэл ямар ач холбогдолтой вэ?

- ❖ Хувь хүний нийгэмд байр сууриа эзлэх, өөртөө болон ирээдүйдээ итгэлтэй байх, өөрийгөө ойлгох, хөгжүүлэх,
- ❖ Үнэнийг тунгаан бодох, тодруулан ойлгох,
- ❖ Эрх, эрх чөлөөгөө зохих ёсоор эдлэх,
- ❖ Ажил хэргээ зөв баримжаалж, зохион байгуулах, аж байдлаа дээшлүүлэх,
- ❖ Улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцын талаар тодорхой төсөөлөл ойлголттой байх,
- ❖ Ардчилсан үйл явцад идэвхтэй оролцох,
- ❖ Зөв шийдвэр гаргахад нөлөөлөх, ардчилсан, үр ашигтай удирдлагыг төлөвшүүлж, түүнд хувь нэмрээ оруулах,

- ❖ Засаг төрийн үйл ажиллагаанд олон түмэн, иргэний нийгмийн зүгээс хяналт тогтоон хэрэгжүүлэх,
- ❖ Шударга ёс хийгээд хууль дээдлэх ёсыг сахин хангах,
- ❖ Эрх тэгш байх боломжоо ашиглах,
- ❖ Төрийн байгууллага, албан тушаалтнууд эрх мэдлээ хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэх,
- ❖ Аливаа хууль бус явдалтай тэмцэхэд санаачлагатай оролцох үндэс болно.



### 3. Би яагаад мэдээлэл олж авах эрхтэй вэ?

Яагаад гэвэл Та төр нь **ИРГЭНДЭЭ** үйлчилдэг  
ардчилсан нийгэмд амьдарч байна.

Энэ нийгэмд та **ТӨРИЙН ЭЗЭН** юм.



Хуучин дэглэмийн үед төр нь иргэдийг үг дуугүй захирч, өөртөө үйлчлүүлдэг нийгэмд бид амьдарч байлаа. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл угтаа зөвхөн нэг намд үйлчилж байв. Ийм нийгэм цөөн тооны хүнээс бүрдсэн удирдах бүлэгт шүтэж, ард түмэн зөвхөн тэдний захиргаадалтын дор оршин байв.



Ардчилсан нийгэмд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүх байгууллага зөвхөн Иргэн Танд үйлчилнэ.

Та нэгэнт ТӨРИЙН ЭЗЭН тул:  
Төрийн байгууллагаа сонгодог  
Төрөө татвараар санхүүжүүлдэг.



Тогтмол хугацаанд болдог чөлөөтэй, шударга сонгууль бол танд улс орныхоо ирээдүйн үйл хэрэгт шийдвэрлэх эрхтэйгээр биечлэн оролцох гол боломж юм. Хамгийн чухал нь Та төрийн хэрэгт шууд орж бие даан эцсийн шийдвэр гаргана. Улс төрийн сонгууль аль хэр шударга болох нь таны аль хэр үнэн зөв мэдээлэлтэй байхаас шалтгаална.



Та сонгуулийн өмнөх улс төрийн намуудын ухуулга сурталчилгаа, сонин хэвлэл, радио телевизийн мэдээлэл сурвалжлага, нэр дэвшигчдийн уулзалт, мэтгэлцээний явцад олж авсан мэдээлэлдээ үндэслэн сонголтоо өөрөө хийнэ. Танд гагцхүү үнэн, бодитой, тэнцвэртэй мэдээлэл ашиг тусаа өгнө.

Нийгэмд хүн бүр албан тушаалын адил эрх мэдэлтэй байх боломж байдаггүй. Тиймээс сонгуульд оролцоно гэдэг нь итгэж сонгосон хүндээ өөрийн нэрийн өмнөөс төрийн шийдвэр гаргах зөвшөөрөл олгож байгаа хэрэг юм.

Иймд сонгуульд албан тушаалтан, эсвэл хэсэг бүлэг хувийн ашиг сонирхлынхоо төлөө эрх мэдлээ урвуулах болон хэтрүүлэн ашиглаж, дур зоргоор авирлахаас сэргийлж, ХЯНАЛТ тавьж байх үүрэгтэй. **Ингэхийн тулд та мэдээлэлтэй байх нь амин чухал.**

### Жишээ

*Таны орлого олигтой нэмэгдээгүй, амьдрал дээшлээгүй байна. Ажилгүйдэл нэмэгдэж, дулаан цахилгааны үнэ өсчээ. Гэтэл таны сонгосон хүн ихэд баяжиж, хувийн үйлдвэр, барилга байшин, тансаг сууцтай болж гэж бодъё. Энэ орлогын эх үүсвэр хэзээ, хаанаас гараад ирэв ээ? Таны итгэсэн хүн авилгад өртөөгүй биз?*

### Жишээ

*Улсын Их Хурал агаарын бохирдлоос сэргийлэх тухай хууль хэлэлцжээ. Энэ нь таны эрүүл мэндийг хамгаалж, эрүүл, аюулгүй орчныг сайжруулахад чухал хууль. Таны сонгосон гишүүн энэ асуудалд яаж хандсан бол? Таны итгэлийг даасан болов уу? Хөсөрдүүлсэн болов уу? Таны эрүүл саруул орчинд амьдрах эрх ашиг сонирхлыг яаж хамгаалсан бэ?*



Та улсад хүн амын орлогын, нэмүү өртгийн гэх мэт 10 гаруй төрлийн татвар төлдөг. Энэ татвар нь улсын төсвийг бүрдүүлж, төр, түүний байгууллагуудын дооод хэрэгцээнд төдийгүй, тэдгээрээс хүн амд үзүүлэх бүх төрийн үйлчилгээнд зориулагдана.

Өндөр настай эцэг, эхээ асрах, өвчин эмгэгтэй үр хүүхдээ эмчлүүлэх гээд амьдралын хамгийн чухал шаардлагаар танд мөнгө хэрэгтэй байлаа ч татвар төлөх ёстой. Учир нь төрийн байгууллагууд танд үйлчлэхийн тулд үйл ажиллагаагаа хэвийн явуулах учиртай.

Харин та мөнгөө хэн нэгэн албан тушаалтнаар үрэн таран хийлгэхгүйн тулд ХЯНАЛТ тавих үүрэгтэй. Үүний тулд танд тогтмол мэдээлэл хэрэгтэй.

### Жишээ нь

*Таны хүүхэд сургуулийн сурагч. Угтаа та сургуулийг халааснаасаа санхүүжүүлж байгаа. Гэтэл сургуулийн захиргаа төсөв хүрэлцдэггүй гэсэн шалтгаанаар засвар, сурах бичгийн, хичээлийн танхим тохижуулах нэрээр эцэг, эхээс байнга мөнгө шаардана. Та тухайн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаатай танилцах эрхтэй. Үүндээ бусад эцэг, эхийг татан оролцуулж, хамтран ажиллах явцад танай хүүхдийн багш, эсвэл сургуулийн захирал төсвийн хөрөнгийг зохисгүй зарцуулж, эсвэл хувьдаа завшсаныг олж мэдэв.*

### Ийм учраас Иргэн Та:

- Төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй
- Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- Та хариуцлагаа сулруулбал төр бохирдож болзошгүй

## 4. Шууд оролцоо гэж юу вэ?

Иргэдийн шууд оролцоо гэдэг нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд төлөөлөгчөөр дамжуулахгүй өөрөө биечлэн оролцож бодлого боловсруулах шийдвэр гаргахад нөлөөлөх, мөн өөрийн төлөөлөгчийг сонгож буйг хэлэх бөгөөд төлөөлөгч нь цааш оролцохыг шууд бус гэнэ. Эдгээр нь хүний эрх, ард түмнийхээ сайн сайхан аж байдлын төлөө төртэй хамтран ажиллаж байгаа хэлбэр юм.



*Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгон байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.*

*(Монгол Улсын Үндсэн Хууль,  
3-р зүйл )*

Иргэд ардчиллын үйл явцад идэвхтэй оролцохгүй бол эрх баригчид, албан тушаалтныг дур

зоргоороо авирлахыг зөвшөөрсөнтэй нэгэн адил болно. Ингэснээр төрийн удирдлагууд хэмжээлшгүй эрхтэн дархтан болж, иргэдийн эрх, эрх чөлөө хумигдан “дарга шүтдэг” дарангуйллын тогтолцоо уруу буцаж очно гэсэн үг юм.

### **Иргэдийн оролцоо шууд бөгөөд идэвхтэй бол:**

- ❖ Эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлнэ.
- ❖ Төр иргэдийнхээ хүсэл, зорилгын талаар мэдээлэлтэй байна.
- ❖ Олон нийттэй зөвшилцсөний үндсэн дээр амьдралд нийцэхүйц зөв шийдвэр гаргана.
- ❖ Төр, түүний байгууллагын үйл ажиллагаа ил тод байж, иргэд илүү мэдээлэлтэй байна.
- ❖ Нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэхэд төр, иргэний нийгэм хамтран ажиллана.
- ❖ Нийгмийн шударга ёс бэхжинэ.

Энэ бүхэнд мэдээлэл чухал үүрэг гүйцэтгэнэ.

Иргэдийн шууд оролцоог хангахын тулд доорхи 3 эрх, эрх чөлөөг хамгаалж, хуульчлах нь туйлын чухал юм.

- ❖ Төлөөлөлтэй байх эрх
- ❖ Мэдээллийн шинжтэй үйлдэл хийх (үйл ажиллагаа явуулах)
- ❖ Мэдэх эрх

## 5. Төлөөлөлтэй байх эрх гэж юу вэ?

Таны төлөөлөлтэй байх эрх сонгох, сонгогдох эрхээр дамжин хэрэгждэг. Сонгуулийг шударга, чөлөөтэй явуулахын тулд хангалттай, үнэн бодитой мэдээлэл амин чухал.

*Монгол Улсын иргэн:  
Сонгох, сонгогдох эрхтэй.  
Үндсэн Хуулийн 16-р зүйлийн  
9 дэх хэсэг*



Та өөрийн сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан төрийн хэрэгт оролцоно. Таны бүрэн эрхт төлөөлөгч УИХ, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо зэрэг бүх шатны эрх барих газарт байдаг.

Та сонгуульд оролцож, саналаа өгөхдөө улс, орон нутгаа хөгжүүлж, аж амьдралаа дээшлүүлнэ гэж итгэж, нааштай өөрчлөлт хийхийн төлөө байдаг.

Ийм учраас та улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалтыг сайтар судалж, биелэх боломжтой, хэрэгтэй эсэх талаар тунгаан бодох хэрэгтэй болно.

Улсын ирээдүй таны сонголтоос ихэд хамаарах учир та сонгуульд хайнга хандах ёсгүй. Зөв сонголт хийх нь таны эрхэм зорилго. **Үүний тулд танд мэдээлэл чухал.**

### Жишээ нь

*Нэр дэвшигч Дорж танай тойрогт сургууль байгуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр амлажээ. Үүнд нэлээн хөрөнгө шаардлагатай нь мэдээж. Энэ бас таны хүсэл, хэрэгцээ гэж бодъё.*

Асуулт: Энэ хөрөнгийг хаанаас олох вэ?

Хариулт: Улсын төсөвт суулгана

*Хариулт тийм хангалттай бус байна. Улсын төсвийг УИХ-аар хэлэлцэх үед энэ тухай яригдах ажээ. Нэгэнт амлалт болохоор нэр дэвшигч сонгогдсон бол энэ асуудлыг төсөвт суулгахаар санал оруулж хэлэлцүүлнэ. Харин батлагдах эсэх нь өнөөдөр тодорхойгүй учир амлалт биелэгдэнэ гэж итгэхэд тагадлал бага юм.*

Магадгүй танд танай хот, аймаг, сум, дүүрэг, багийн өнөөгийн төсөв, шинэ сургуультай болсноор нэмэгдэх төсвийн хэмжээ, шинэ сурагч, багшийн тоо зэрэг олон мэдээлэл шаардлагатай болно. Гэхдээ та зөв сонголт хийхийн тулд эргэцүүлэн бодож, **мэдээлэл цуглуулж дүгнэлт хийх хэрэгтэй.**

### Жишээ нь

*Тухайн тойрогт өрсөлдөж буй өөр нэг нэр дэвшигч “сонгогчдынхоо итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг амьдрал дээр бодитой хангах механизм бий болгох”-ыг атлав.*

*Энэ атлалт биелэгдвэл таныг өөр үзэл бодолтойн улсаас хэн ч ялгаварлан гадуурхахгүй, хавчиж дарамтлахгүй, шагналаас хасахгүй, ажлаас чинь халахгүй нь бололтой.*

*Та аливаа дарамт шахалтгүйгээр бодсон санаснаа хэлж, ажил сайжруулахын төлөө шүүмжлэл өрнүүлж, удирдлагынхаа буруу шийдвэрийг эсэргүүцэж болох юм.*

*Таны чөлөөтэй, айдасгүй амьдрах нөхцөл сайжирна. Та тунгаан бодохын тулд бусадтайгаа санал солилцож, тэдээлэл цуглуулах хэрэгтэй.*

Жишээ нь

*Байз, байз.*

*Энэ хоёр нэр дэвшигч хоёулаа сайхан, хэрэгтэй зүйл амалж байна. Амлалтаа хэрхэн биелүүлэхийг хэмжих үзүүлэлт бүрхэг байна. Тэгвэл хэн нь илүү шударга, итгэл даах чадвартайг яаж мэдэх вэ? Үнэхээр миний төлөө юу, эсвэл хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөв үү? Аль хэр нэр хүндтэй хүн бэ? Аль хэр шударга хүн бэ? Урьд өмнө худал амлаж, хуурч тэхлээгүй биз? Янз бүрийн хэрэг төвөгт орооцолдож байгаагүй биз?*

*Мэдээлэл,  
Мэдээлэл,  
Мэдээлэл чухал байна.*



## 6. Мэдээллийн чанартай үйлдэл хийх эрх гэж юу вэ?

Ийм үйлдэл хийх эрх нь цуглаанд оролцож, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргагчдад хандан захидал илгээх, мэдэгдэл хийх, ухуулга хуудас хэвлэж тараах, хэвлэл мэдээлэлд хандах, хэвлэл мэдээллийн аян, жагсаал цуглаан зохион байгуулах, суулт хийх, ажил хаях, өлсгөлөн зарлах гэх мэт олон хэлбэрээр хэрэгжинэ. Та аливаа үйлдэл хийх, үйл ажиллагаа явуулахын тулд эвлэлдэн нэгдэх эрхтэй.



*Үндсэн Хууль (16. 10)*

*Монгол Улсын иргэн:*

*Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй.*

Эвлэлдэн нэгдэх эрх гэж ижил ашиг сонирхол, үзэл бодолтой хүмүүс хууль ёсны зорилгоор төрд дуу хоолойгоо хүргэж, зохих шийдвэр гаргуулахын төлөө нэгдэж, хамтран ажиллахыг хэлнэ.

### Жишээ нь

*Элч нар эвлэлдэн нэгдэв. Учир нь элчлэгийн удирдлага элчилгээний зардлыг багасгаж, өвчтнүүдээс эл тариаг нь гаргах шийдвэр гаргаж, үүнийгээ төсөв хүрэлцээгүй хэтээн тайлбарлав.*

*Үүнийг элч нар тангараг зөрчих хууль ёс зүйд харшлах шийдвэр гэж үзэж, эсэргүүцлээ илэрхийлэн өргөх бичиг барив. Гэтэл удирдан зохион байгуулсан элч нарыг захиргааны шийдвэр эсэргүүцсэн хэтээн цалингаас нь хасах тушаал гаргав. Хариуд нь элч нар төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийлгэжээ. Энэ явцад элчлэгийн дарга төсвийн хөрөнгийг зүй бусаар ашигласан нь тогтоогджээ.*



- ❖ Таны сонгосон улс төрчид, тэдний томилсон албан тушаалтнууд буруу шийдвэр гаргаснаас ард түмний аж амьдрал дээшлэхгүй бол,
- ❖ Нийгэмд авилга, гэмт хэрэг зэрэг сөрөг үзэгдлүүд газар авч, олон нийт айдас хүйтэст автвал,
- ❖ Төсвийн хөрөнгө зориулалтаараа зарцуулагдахгүй бол,
- ❖ Албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулах, эсвэл хэтрүүлэн, өөрийн ашиг сонирхлыг илүү чухалчилж байвал Та шүүмжилж, эсэргүүцэх эрхтэй.

**Ийм учраас мэдээлэл хайх, цуглуулах түгээх нь чухал.**

## Жишээ нь



*Таны орон сууцны яг дэргэд шинэ барилга барьсны улмаас нарны гэрэл үзэхээ болив. Энэ нь таны эрүүл мэндэд муу нөлөөтэй. Та үүнийг эсэргүүцэхийн тулд буруу гэдгийг нотлох ёстой. Хоёр барилгын хоорондын зай ямар байх ёстой вэ? Үүнд ямар нэг дүрэм журам үйлчилдэг байгаа. Та “Хот байгуулалтын хууль”, “Барилгын тухай хууль”, “Эрүүл*

*мэндийн тухай хууль”, тэдгээрийн дагуу гарсан “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” зэрэг баримт бичиг олж үзжээ. Эндээс олж авсан мэдээллээр бол таны эрх зөрчигдсөн байна. Та энэ мэдээллээ хөршүүдтэйгээ хуваалцаж, халтран тэмцэхээр болов. Тэмцлийн явцад та тухайн газрыг тодорхой нэг эрх мэдэлтнийг хахуульдан олж авсныг олж илрүүлжээ.*

*Монгол Улсын иргэн:*

*Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй.*

*Үндсэн Хууль 16. 16*



Та аливаа асуудлаар засаг төрийн байгууллагын анхаарлыг хандуулах, үүнийхээ төлөө үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхээр тайван жагсаал цуглаан, уулзалт, чуулган зохион байгуулж болно.

Энэ бүхний үндэслэл нь бодитой мэдээлэл байдаг.

## Жишээ нь

*Дээд сургуулийн захиргаа сургалтын төлбөрийг нэмэх шийдвэр гаргах гэж буйг оюутнууд олж тэджээ. Оюутны зөвлөл үүнийг эсэргүүцэн шалтгаанаа тайлбарлахыг шаардсан тэдэгдэл гаргасан боловч сургуулийн захиргаа үл тоомсорлов.*

*Оюутны зөвлөл дахин хуралдаж, хичээлийн цагаар цуглаан зохион байгуулахаар шийдвэрлэжээ. Гэтэл сургуулийн захиргаа зохион байгуулагчдыг сургуулиас хасах шийдвэр гаргав. Энэ нь эсэргүүцлийн жагсаал болон өргөжсөн байна.*



## 7. Мэдэх эрх гэж юу вэ?

Таны мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг МЭДЭХ ЭРХ гэж нэрлэдэг. Энэ эрх чөлөөгөө эдэлснээр та жинхэнэ эрх мэдэлтэй болж, төрийг өөртөө үйлчлүүлэх бодитой механизм бүрдэнэ. Мэдээлэлтэй байх нь үр өгөөжтэй, ардчилсан удирдлагын амин сүнс юм. Та мэдээлэлтэй болсноор улс оронд болж буй хэрэг явдлын талаар үнэн бодит ойлголттой болж, нийгэмд зөвшил итгэлцэл бий болно. Үнэнийг худал цуу яриа, буруу ташаа мэдээллээс ялгаж ойлгох нь төр, иргэдийн хооронд түншлэл, итгэлцэл бий болоход чухал үүрэг гүйцэтгэнэ.


Таны МЭДЭХ ЭРХ бол Үндсэн Хуулиар баталгаажуулсан таны бусад эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх нэгэн үндэс юм.

## 8. Би ямар аргаар МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ВЭ?

Иргэд мэдээлэл олж авах олон арга бий. Хэлбэр нь бичиг, ам, хэвлэл, радио гэх мэт байна.

- ❖ Мэдээлэл бүхий хүмүүстэй уулзах, тухайлбал, улс төрчид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид, эрдэмтэн багш нар, олон нийтийн зүтгэлтнүүд, УИХ-ын гишүүд, орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчид уулзаж ярилцах, асуулт асуулга тавьж, хүсэлт гаргаж хариулт авах,
- ❖ Тодорхой алба хашиж буй албан тушаалтан, ажилтан, мэргэжилтэн Засгийн газар, нутгийн захиргааны болон түүний харьяа байгууллагаас албан ёсоор шаардан мэдээлэл авах,
- ❖ Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээс мэдээлэл олж үзэх, уншиж судлах,
- ❖ Хурал, чуулган, шүүх хуралд суух,

- ❖ Олон нийтийн арга хэмжээнд оролцох,
- ❖ Эх материал, лавлах, ном бусад эх сурвалж ашиглах,  
Номын сангууд ямагт мэдээллийн сайн эх сурвалж болдог.
- ❖ Бусад иргэдтэй мэтгэлцээн хийх,
- ❖ Сургалт, семинарт суух гэх мэт бусад олон арга зам байдаг.



Аль ч аргаар олж авсан мэдээллийн эх сурвалжуудыг харьцуулах, үнэн бодитой эсэхийг шалгах нь нэн чухал.

## 9. Миний мэдээлэл олж авах эрхийг яаж хуульчилсан бэ?

Манай улсад иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хангах арга замыг нарийвчлан зааж, баталгаажуулсан хууль хараахан байхгүй. Харин үндсэн эрхийн тухайд дараахи хууль, баримт бичгүүдээр баталгаажсан байдаг.

- ❖ Монгол Улс НҮБ-ын гишүүний хувьд нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээж буй үүрэг
- ❖ Монгол Улсын Үндсэн Хууль

1. Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүн болсноор Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн юм. Энэхүү Тунхаглалын 19-р зүйлд **“аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хил заагаар үл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх”** эрхтэй хэмээн тунхаглаж, баталгаажуулсан байдаг.

Манай улс 1974 онд Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактад нэгдэн орсон бөгөөд үүгээрээ 19-р зүйлийн **“төрөл бүрийн мэдээлэл болон үзэл**

санааг хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрх”-ийг хүлээн зөвшөөрсөн юм.

*Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ*

*(Үндсэн Хууль 10.2)*

*Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ*

*(Үндсэн Хууль 10.3)*

## 2. Монгол Улсын Үндсэн Хууль

*Монгол Улсын Иргэн нь: Мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. (Үндсэн Хууль 16.17)*

Үндсэн Хуулийн дээрх хоёр заалтын дагуу Олон Улсын Пактын 19-р зүйлийн заалт нь манай улсад дотоодын хуулийн адил үйлчлэх юм.

3. Дэлхий дахины чөлөөт илэрхийллийн төлөө “19-р зүйл” гэдэг олон улсын байгууллагаас 1995 онд “Йохан-насбургийн зарчмууд”, 1999 онд “ Олон нийтийн мэдэх эрх мэдээллийн эрх чөлөөний хуулийн олон улсын зарчмууд” зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, тэдгээрийг НҮБ хүлээн зөвшөөрч баталсан байдаг. Эдгээр баримт бичигт олон нийтийн мэдэх эрх нь төрийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтан, албан хаагчдын ашиг сонирхлоос илүү давуу бөгөөд үндэсний аюулгүй байдлын тусын тулд хийх хязгаарлалт нь гагцхүү хуулийн хүрээнд, нарийвчилсан, тодорхой байвал зохихыг чухалчилсан байдаг.

*Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэт хэтжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэтлэсэн гадаад бодлого явуулна.*

*(Монгол Улсын Үндсэн Хууль 10.1)*



## 10. Би ямар мэдээлэл олж авах эрхтэй вэ?

Ардчилсан нийгэмд “бүх мэдээлэл олон нийтэд ил тод байна” гэдэг олон улсын жишиг, хэм хэмжээ байдаг бөгөөд доорхи хоёр зарчим үйлчилдэг:

- ❖ Мэдээллийг олж авах нь чөлөөтэй байх
- ❖ Мэдээллийг олж авах нь хязгаарлалттай байх

Мэдээлэл олж авах, түгээх эрхийг олон улсын хэм хэмжээнд заасанчлан дор дурьдсан үндэслэлээр зөвхөн хуулиар хязгаарлаж болдог. Үүнд:

- ❖ Бусдын эрх, алдар хүндийг хамгаалах
- ❖ Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд болон ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй байвал гэсэн үндэслэл бий.

Мэдээлэл нь хаалттай байдаг нийгмээс нээлттэй тогтолцоонд шилжих явцад манай улсад нууцын асуудлаар мэдээлэлд нэлээд хязгаарлалт тогтоосон онцлог бий. Иймд нууцтай холбоотой хуулиудыг Та мэдэж байх хэрэгтэй.

## 11. Манай улсад ямар мэдээллийг нууцалдаг вэ?

Манай улсад зарим мэдээллийг нууцалсан доорхи хууль үйлчилдэг.

- ❖ Төрийн нууцын тухай /1995.04.18/
- ❖ Байгууллагын нууцын тухай /1995.05.16/
- ❖ Хувь хүний нууцын тухай хууль /1995.04.2 1/
- ❖ Эрүүгийн хууль, Геодези зураг зүйн тухай зэрэг салбарын зарим хууль тогтоомж.



- ~~⊗~~ Төрийн нууц
- ~~⊗~~ Байгууллагын нууц
- ~~⊗~~ Хувь хүний нууц
- ~~⊗~~ Зарим хууль

## 12. Төрийн нууцын тухай хуулиар ямар мэдээллийг нууцад хамааруулсан вэ?

Төрийн нууцын тухай хуулиар мэдээллийг доорхи хүрээнд нууцлахаар баталсан байдаг. Үүнд:

- а. Үндэсний аюулгүй байдал
- б. Батлан хамгаалах
- в. Эдийн засаг, шинжлэх ухаан, технологи.

## 13. Байгууллагын нууцад ямар мэдээлэл багтдаг вэ?

Энэ хуулиар тухайн байгууллага өөрөө нууцаа тогтоодог бөгөөд нууцаа хамгаалах журмыг баталж мөрдөх үүрэгтэй. Таны хүссэн мэдээллийг өгөхгүй бол нууц мэдээллийн жагсаалттай танилцахыг хүсээрэй. Түүнд дээр дурьдсан олон улсын хэм хэмжээгээр зөвшөөрсөн хязгаарлалтаас бусад мэдээллийг нууцалсан ч байж болзошгүй. Учир нь нийгмийн шилжилтийн явцад хуучин соёл, уламжлалаас харахан ангижирч чадаагүй байгаа тул удирдах ажилтан, албан хаагчид мэдээллийн чөлөөтэй байдал, ил тод зарчмын тухай ойлголт сул байдаг. Энэ нь ихэнх тохиолдолд санамсаргүйгээр энгийн мэдээллийг ч нууцын ангилалд оруулахад хүргэдэг.

*Байгууллага нь хүн амын эрүүл тэнд, байгаль орчинд эрсдэл учруулж болзошгүй болон гэтт хэргийн тухай мэдээллийг нууцлах ёсгүй*

*(Байгууллагын нууцын тухай хууль 6-р зүйл )*

### Жишээ нь

*Танай хүүхэд гадаадад суралцахаар шалгалтандаа тэнцсэн боловч хөрөнгө мөнгөний асуудал шийдвэрлэгдэхгүй байна. Та улсын зардлаар гадаадад суралцдаг оюутнуудын нэрсийн жагсаалтыг үзэх хүсэлт гаргажээ. Танд үүнийг төрийн нууц, эсвэл байгууллагын нууц, эсвэл хувийн нууц гэсэн шалтгаанаар татгалзаж тагадгүй.*



*Төрийн нууцад ийм мэдээлэл багтдаггүй. Байгууллага ч нууцлах ёсгүй. Улсын зардал гэдэг нь угтаа бидний мөнгө. Энэ мэдээллийг олж явах явцад та гадаадад суралцдаг оюутнуудын дийлэнх хэсгийг өндөр албан тушаалтны хүүхдүүд эдэлж буйг олж мэдэв.*

Энэ нь хувь хүний нууц биш бөгөөд эрх тэгш байдлыг хангах, албан тушаалын байдал, эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэхтэй холбоотой мэдээлэл учраас аливаа нууцад хамаарах ёсгүй юм.

## 14. Би хувь хүний талаар хүссэн мэдээллээ олж авах эрхтэй юу?

Ардчилсан нийгэмд хүний эрхийг баталгаажуулахдаа бусдын эрхийг зөрчихгүй байхад нийцсэн хязгаарлалт тогтоодог. Хувь хүний нууцын тухай Монгол Улсын хуульд “хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Хувь хүний нууцын төрөл:

- ❖ Захидал харилцааны
- ❖ Эрүүл мэндийн
- ❖ Хөрөнгийн
- ❖ Гэр бүлийн гэх мэт.



*Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хатаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална*

*(Үндсэн Хууль 16. 17)*

### Жишээ нь

*Та нийтийн эмнэлгээс тухайн байгууллагын төсөв, төсвийн гүйцэтгэл, эмчилгээтэй холбоотой даргын тушаал, ажиллагсдынх нь цалингийн сүлжээ зэрэг олон төрлийн мэдээллийг олж авах эрхтэй. Гэвч хувь хүний цалингийн орлого, өөр өвчтний өвчний түүх, эмчилгээний арга зэргийг шаардаж болохгүй. Харин таны өвчний түүх танд нээлттэй байх нь зүйн хэрэг.*



Харин өндөр албан тушаал эрхэлж буй хүмүүсийн хувьд жил бүр хөрөнгө орлогынхоо тухай тайлагнах үүрэгтэй.

Гэхдээ “Авилгын эсрэг хуульд” тухайн албан тушаалтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгө орлогын мэдүүлгийг ил болгоно” гэсэн байдаг.

Хэрэв та сонгуулийн кампанит ажлын үеэр нэр дэвшигчээс өөрийнх нь орлогыг сонирхвол тэр өөрөө зөвшөөрч, хариулах ёстой.

Тухайн хүн өндөр албанд очсоноос хойш бүрэн эрхийнх нь хугацаанд хөрөнгө санхүүгийн байдал нь хэрхэн өөрчлөгдөж буйд хяналт тавих нь таны эрх төдийгүй үүрэг юм.

Энэ нь эрх мэдэлтнүүдийн албан тушаалаа урвуулан ашиглах, хээл хахуульд холбогдох зэрэг авилгалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ч тустай.

## 15. Манай улсад мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах хууль байдаг уу?

Манай улсын хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн тухай мэдээллийг ил тод байлгах хуулийн зарим заалт үйлчилдэг.

*Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг “Төрийн мэдээлэл” элхэтгэлд мэдээлнэ.*

*(Засгийн газрын тухай хууль 31.1)*

*УИХ-ын хуралдаан нээлттэй байх бөгөөд шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.*

*(УИХ-ын дэгийн тухай хууль 4.9)*

*УИХ-ын хууль, бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, яамдын эрх зүйн актыг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтэлнэ.*

*(УИХ-ын дэгийн тухай хууль 46.1)*

*Төрийн өмчийн хороо улсын үйлдвэрийг хувьчлахын өмнө энэ тухай нийтэд мэдээлэх ёстой.*

*(Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 36.1)*

## 16. Төрийн байгууллагад ямар мэдээлэл хадгалагддаг вэ?

Төрийн байгууллагуудад таны өдөр тутмын үйл хэрэг, аж амьдралтай шууд хамаатай маш олон мэдээлэл хадгалагдаж байдаг.

### Жишээ нь

- ❖ *Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо албан тушаалтны тухай судалгаа, ажил үүргийн хуваарь, бодлогын тухай,*
- ❖ *Байгууллагын шийдвэр, байгууллагын болон түүний эрх мэдлийг үйлчилгээний төсөв, түүний зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны тухай,*
- ❖ *Албан тушаалтнуудын эрх хэтжээ, ажил үүргийн хуваарь,*
- ❖ *Байгууллагын дотоод дүрэм, журам,*
- ❖ *Хүн амд зориулсан үйлчилгээний тухай тушаал, шийдвэр, дүрэм, журам,*
- ❖ *Иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хангахтай холбоотой бичиг захидал, бичиг баримт,*
- ❖ *Бусад.*

## 17. Би байгууллагаас ямар аргаар мэдээлэл олж авах вэ?



- ❖ Байгууллагад өөрийн биеэр очиж хүсэлт гаргах, шаардлага тавих,



- ❖ Байгууллагын хурал, цуглаан уулзалтад оролцох,
- ❖ Байгууллагын танилцуулга, тайлан, эмхэтгэл, вэб сайт, сурталчилгааны хуудас гэх мэтийг ашиглах,



- ❖ Байгууллагын удирдлагад асуулга тавих, захидал илгээж, хариу авах,
- ❖ Үйл ажиллагааны тайлан сонсох.

Та байгууллагаас боломжтой бүх хэлбэрээр мэдээлэл олж авах эрхтэй.

- ❖ Бичмэл
- ❖ Хэвлэмэл
- ❖ Дүрс бичлэг
- ❖ Гэрэл зураг
- ❖ Цахим мэдээлэл
- ❖ Ам тайлбар
- ❖ Хурал цуглаан
- ❖ Бусад.

## 18. Би байгууллагаас мэдээлэл олж авахын тулд хэнд хандах ёстой вэ?

Та тухайн байгууллагын бүх албан тушаалтанд хандан мэдээлэл авах эрхтэй

- ❖ Удирдах албан тушаалтан
- ❖ Мэдээлэл харилцааны, хэвлэл мэдээллийн албаны ажилтан
- ❖ Архивын эрхлэгч
- ❖ Нарийн бичгийн дарга
- ❖ Бусад зохих ажилтан

## 19. Мэдээлэл авсныхаа төлөө би төлбөр төлөх үү?

Мэдээлэл олж авах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан боловч түүнийг хангах журмыг тодорхойлсон хууль одоогоор байхгүй. Үүнээс шалтгаалан байгууллага дотроо өөр өөр дүрэм журам тогтоосон байна.

Үүнд зарим төлбөр байхыг үгүйсгэдэггүй боловч засаг төрийн байгууллага иргэдэд ганцаарчлан өгөх мэдээллийг төлбөржүүлэх нь зохисгүй юм.

## 20. Би мэдээлэл олж авах шалтгаанаа тайлбарлах ёстой юу?


Ямар мэдээлэл хүсэж байгаагаа тайлбарлах нь зайлшгүй боловч ямар зорилготой хүсэж байгаагаа тайлбарлах үүрэг, албагүй юм.

## 21. Таны хүссэн мэдээллийг нууцад хамруулах өөр шалтгаан бий юу?

Байхгүй. Хэрэв албан тушаалтан, ажилтан мэдээлэл өгөхөөс татгалзвал шалтгаанаа заавал нотлох ёстой.

Мэдээллийн эрх чөлөөний хуультай орнуудад мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсан албан тушаалтан, албан хаагчид захиргааны хариуцлага ногдуулдаг байна.

Харин гэмт хэргийг нуун дарагдуулах зорилгоор мэдээлэл өгөхөөс татгалзвал эрүүгийн хариуцлагад таах үндэслэлтэй болдог.




## 22. Мэдээлэл өгөхөөс татгалзвал яах вэ?

Та гомдлоо дээд шатны байгууллагад нь тавих, хэрэв хуульд заасан захиргааны маргаан байвал шүүхэд нэхэмжлэх эрхтэй. Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд дараах үе шатыг баримталж болно.

- ❖ Дээд албан тушаалтанд нь хандан амаар болон бичгээр гомдол гаргана. Манай улсад “иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль” үйлчилж байгаа болно.
- ❖ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу Захиргааны хэргийн шүүхэд хандах үндэслэл байж болно.
- ❖ Дээд Шүүхэд хандах Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хуулийн зохих заалтууд танд үйлчилнэ.

- ❖ Хэрэв үндсэн эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн Хуулийн Цэцэд хандаж болно. Түүнийг Үндсэн Хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- ❖ (А) Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн дагуу Хүний Эрхийн Үндэсний Комисст хандах
- ❖ (Б) Та НҮБ-ын гишүүн улсын иргэний хувьд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газарт хандан хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах эрхтэй.



## 23. Мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг хангах үндэслэл, журмыг тусгайлан хуульчлах шаардлагатай юу?

Энэ нь чухал шаардлагатай. Үндсэн Хуулиар таны эрхийг тунхагласан бол Мэдээллийн эрх чөлөөний хуулиар энэ эрхийг амьдрал дээр хэрэг-жүүлэх нарийвчилсан арга зам, журмыг тогтоож баталгаажуулна.

Сүүлийн жилүүдэд бусад улс орнуудад мэдээллийн эрх чөлөөний хууль чухал болохыг ойлгон хууль боловсруулж, батлуулах санаачлага, хөдөлгөөн өрнөж байна. Одоогоор дэлхийн 50 гаруй орон иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг хангах журмыг хуульчлан хэрэгжүүлж байгаагийн 40 нь 1992 оноос хойш, 20 нь 2000- 2003 онд батлан мөрдүүлжээ. Ялангуяа манай оронтой адил ардчилсан шилжилтийн үеийн Албани, Болгар, Гүрж, Кыргыз, Латви, Словак, Чех, Эстон зэрэг олон орон ийм хуультай болсон байна.

ОХУ “Мэдээлэл, мэдээлэлжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулиндаа иргэдэд мэдээлэл өгөх албан тушаалтнуудын үүргийг тодорхойлжээ. Манай улс ч мөн ийм хуулийг баталж мөрдөхийг “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал”, “Авилгатай тэмцэх” үндэсний хөтөлбөр болон Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрүүдэд тусган заасан. Энэ асуудлаар Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Ийм хууль тогтоомж нь олон улсын холбогдох хэм хэмжээнд нийцсэн байх ёстой.



## 24. Мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээнд юу багтдаг вэ?


Олон улсын хэм хэмжээний дагуу хуульд дор дурьдсан үндсэн 9 зарчмыг зайлшгүй тусгахыг чухалчилсан байна.

- ❖ Төрийн байгууллагуудад байгаа мэдээлэл нь олж мэдэхэд дөхөмтэй бөгөөд дээд зэргээр нээлттэй байх.
- ❖ Төрийн байгууллагууд нь нийтэд чухал мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэгтэй байх.
- ❖ Төрийн байгууллагууд эрх мэдлээ нээлттэй хэрэгжүүлэхийг идэвхийлэн дэмжих.
- ❖ Мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан үндэслэл, журам нь нэн ойлгомжтой, нарийн тодорхой, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд нийцсэн байх.
- ❖ Иргэдийн мэдээлэл олж авах үйл ажиллагааг хөнгөвчилсөн байх ёстой. Төрийн байгууллагууд иргэдийн мэдээлэл олж авах эрхийг бүрэн хангаж чадахуйц дотоод журам тогтолцоог бий болгосон байх.

- ❖ Хувь хүмүүс мэдээлэл олж авахад илүүц өндөр төлбөр тогтоох ёсгүй.
- ❖ Төрийн байгууллагын хурал, хуралдаан хуульд ил тод тусгайлан зааснаас бусад тохиолдолд олон нийтэд нээлттэй байх. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хаалттай хурал, цуглаан хийх ёсгүй.
- ❖ Дээд зэргээр нээлттэй байх боломж, зарчимд харшилсан, зөрчилдсөн хууль тогтоомжийг өөрчлөх ёстой.
- ❖ Гэм буруутай аливаа үйлдлийн тухай мэдээлэл түгээсэн иргэн-мэдээлэгчийн эрх, аюулгүй байдлыг хамгаалан хангах ёстой.

## 25. Мэдээллийн эрх чөлөөний тухай болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль хоёр ялгаатай юу?

Энэ хоёр хууль нь ялгаатай. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль бол иргэн бүрт хамаатай, хүний эрхийг баталгаажуулсан хууль юм. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид жирийн иргэний адил мэдээлэл олж авах эрхтэй.



1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль бол хэвлэл мэдээллийн байгууллага буюу “хэрэгсэл”-ийн чөлөөт байдлыг бататгасан хууль юм. Харин хэвлэн нийтлэх эрх чөлөө бол мөн таны үндсэн эрх чөлөөний нэг хэсэг юм.

Ардчилсан нийгэмд олон түмний хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг төр, аливаа нам, улс төрийн бүлэглэлд харьяалагдан үйлчлэхэд бус, харин нийт иргэний мэдээллийн болон хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хангахад үйлчилдэг.

Тухайлбал таны үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх талбар болохын сацуу үнэн бодит мэдээллээр иргэдийн хэрэгцээг хангаж, төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль бус явдлыг илчлэн, хүний эрхийг хамгаалах үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь таны мэдээлэл олж авах нэг суваг мөн. Харин зарим тохиолдолд таны хүссэн мэдээллээр бүрэн дүүрэн хангаж чадахгүй "эрх баригчдад үйлчлэх" аваас дээрх үүргээ умартсан хэрэг гэж үздэг.

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд цагдан хяналт тогтоохыг хориглохын хамт тэдгээрээс төрийн өмнө ямар нэг үүрэг хүлээж гүйцэтгүүлэхээр хуульчлан шахалт үзүүлэхийг хүлээн зөвшөөрч болохгүй юм. Хэвлэл мэдээлэлд засаг захиргааны үүрэг ногдуулах, цагдан хяналтыг тогтоох, эрх чөлөөг нь үндэслэлгүй хязгаарлах нь захиргаадах дэглэмийн нэг гол эрмэлзлэл, шинж байдаг. Тэгвэл ардчилсан оронд хэвлэл мэдээлэл төрөөс хараат бус, чөлөөтэй байдаг тул иргэдийг мэдээллээр хангах төрийн үүргийг гүйцэтгэх ёсгүй юм.

## 26. Төр мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээдэг үү?

Тийм ээ. Жинхэнэ ардчилсан, шударга, авилгалаас ангид, нууцаар хуйвалдахыг цээрлэдэг цэвэр ариун буюу “тунгалаг” төр энэ үүргээ чандлан биелүүлнэ. Иргэдийн мэдээлэл олж авах эрх, түүнийг хангах бүхий л нөхцөлийг хуульчлан баталгаажуулах нь төрийн нэг үүрэг юм.

Ардчилсан нийгэмд төрийн байгууллагууд нь иргэний нийгэмдээ үйлчлэгч байх үүрэгтэй гэж үздэг. Үүнд яам, агентлаг гэх мэт Засгийн Газрын болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн өмчийн болон санхүүжилт бүхий бүх шатны сургууль, эмнэлэг, эрүүл мэндийн зэрэг албан газар, аж ахуйн сүлжээ нь өөрийн бодлого, үйлчлэх үүрэг хэрхэн биелүүлж байгаагаа тайлагнаж, ил тодоор мэдээлж таниулах үүрэгтэй. Энэ бол ил тод байх зарчим юм. Мэдээллийн эрх чөлөө нь улс оронд юу болж буйг нээлттэй байлгаж, мэдэх боломжийг хүмүүст олгохыг шаарддаг юм. Энэ бол засаг төрийн байгууллага, албан тушаалтны хувьд үзэмжийн биш, харин ард түмнийхээ өмнө хүлээсэн хууль ёсны үүрэг хариуцлага юм.



## 27. “Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал ба иргэдийн мэдээлэл олж авах эрх” сэдэвт судалгааны дүнгээс

Энэхүү судалгаа нь төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, мэдээллийн системчлэл, харилцаа, байгууллагын нууц, түүний жагсаалт, байгууллагын үйл ажиллагаа, ажлын үр дүнг олон нийтэд мэдээлэх, түгээх болон иргэдийн төр, захиргааны байгууллагаас мэдээлэл олж авах эрхийн төлөв байдлыг тодорхойлох зорилготой 2002 оны 12 сараас 2003 оны 4 сар хүртэл хугацаанд явуулсан юм.

### Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлын талаар:

Ардчилал нь ил тод байдал ба түүний төлөөх хүчин чармайлтаар тодорхойлогдоно. Монгол улсад төрийн байгууллагууд ил тод нээлттэй байх, олон нийтэд мэдээлэл түгээх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг бүхий газар, хэлтэс, албыг байгуулан ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан 47 байгууллагын 36 байгууллага нь газар, хэлтэс, алба, хэвлэлийн төлөөлөгчтэйгээр дээр дурьдсан үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр газар, хэлтэс, алба нь дор дурьдсан үйл ажиллагаа, үйлчилгээг явуулдаг байна.

д/д	Чиг үүрэг	Төрийн байгууллага /тоо/
1	Байгууллагын үйл ажиллагаа, ажлын үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлэх	29
2	Иргэдэд мэдээлэл өгөх үйлчилгээ	23
3	Тайлан мэдээ, баримтыг нэгтгэн дотоод, бусад байгууллагын хэрэгцээнд тараах	21
4	Мэдээллийг төрийн, төрийн бус болон хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагад өгөх үйлчилгээ үзүүлэх	21
5	Статистик тоо, баримтыг харьцуулан дүн шинжилгээ хийж удирдлагад танилцуулах	17
6	Байгууллагын удирдлагын ажлын талаар мэдээлэх	15

Мөн судалгаанд оролцсон байгууллагын 29 байгууллага нь өөрийн байгууллагын мэдээллийн системийг “системтэй бөгөөд кодлогдсон” байдлаар хадгалдаг байна. Байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийг бусад төрийн байгууллага, албан хаагч, иргэд ашиглах боломж ямар байдаг талаар тодруулахад 34 байгууллага “хангалттай сайн”, “хангалттай”, 4 байгууллага “дунд зэрэг”, 2 байгууллага “хангалтгүй” гэжээ. Мөн мэдээллийг 33 байгууллага “дахин ашиглах”, 26 байгууллага “нийтийн хүртээл болгох” зорилгоор тус тус хадгалдаг гэж хариулсан юм.

Судалгаанд оролцсон нийт төрийн байгууллагаас 29 байгууллага интернэтэд өөрийн вэб хуудастай байна. Төрийн байгууллагад хадгалагдаж байгаа мэдээлэл нь ихэвчлэн электрон болон бичмэл, баримт бичиг, дүрс дуу авиа зэрэг хэлбэрээр хадгалагдахаас гадна мэдээллийн систем нь системтэй бөгөөд кодлогдсон, эмх цэгцтэй байдаг гэж дүгнэж болохоор байна.

Төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа мэдээллийн төрөл, агуулга, хүрээг судалгаанаас үзэхэд:

д/д	Төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа мэдээллийн төрөл, агуулга, хүрээ	Төрийн байгууллага /тоо/
1	Уулзалт, хурал, семинар зохион байгуулсан тухай мэдээлэл	33
2	Байгууллагын сурталчилгаа	29
3	Олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал	26
4	Байгууллагын үйл ажиллагаа болон үр дүнгийн тухай тогтмол гаргадаг мэдээлэл	22
5	Байгууллагын удирдлагын үйл ажиллагааны тухай мэдээлэл	16
6	Иргэд, олон нийтээс танай байгууллагад шууд хандан мэдээлэл хэрхэн хүсэх тухай	11
7	Байгууллагын тухай тогтмол мэдээлэл, түүний дотор зорилго, зардал, тайлан тооцоо, орон тоо, бүтэц, үр дүнгийн тухай мэдээлэл	8
8	Байгууллагад хадгалагдаж буй мэдээллийн төрөл, зүйл, хэлбэр	4

Төрийн ихэнх байгууллагууд байгууллагынхаа тухай тогтмол мэдээлэл, түүний дотор байгууллагын зорилго, зорилт, чиг үүрэг, төсөв, бүтэц, зохион байгуулалт, иргэдэд үзүүлдэг үйлчилгээ, ажлын үр дүнгийн талаар иргэдэд мэдээлэх бус, харин голчлон хурал, уулзалт, семинар зохион байгуулсан тухай болон удирдлагын үйл ажиллагааны тухай мэдээлэл, байгууллагын сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээдэг байдал харагдаж байна.

Судалгаанд оролцогчид олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал (26 байгууллага), байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн тухай тогтмол мэдээлэл (22 байгууллага) түгээдэг гэж хариулсан боловч төрийн байгууллагын ийм мэдээлэл хомс байдаг билээ.

## Иргэдийн мэдээлэл олж авах эрхийн талаар:

Судалгаанд оролцогчид Монгол улсын иргэд төрийн байгууллагаас төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, олж авах эрхтэй гэдгийг бүгд дэмжсэн байна. Харин “төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хориглосноос бусад мэдээллийг танай байгууллагаас чөлөөтэй олж авах боломж хүн бүрт бий юу” гэсэн асуултад “тийм” гэж 39 байгууллага, 6 байгууллага “үгүй” гэж хариулсан байна. “Үгүй” гэж хариулсан байгууллагууд нь

1. Тагнуулын Ерөнхий Газар
2. СБД-ийн ИТХ
3. Иргэний нисэхийн ерөнхий газар
4. Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
5. Сүхбаатар Дүүргийн шүүх
6. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар

Танай байгууллагаас ямар субъект мэдээлэл чөлөөтэй олж авах боломжтой, эрхтэй вэ гэсэн асуултад:

д/д	Төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа мэдээллийн төрөл, агуулга, хүрээ	Төрийн байгууллага /тоо/
1	Төрийн байгууллага	39
2	Төрийн албан хаагч албан шугамаар	35
3	Төрийн бус болон хувийн байгууллага мэдээлэл авах хүсэлтээ албан ёсоор гаргасан тохиолдолд	35
4	Иргэн хүн зорилгоо тайлбарласны үндсэн дээр	32
5	Мэдээлэл агуулга, тоо, хэмжээ, багтаамжаас хамаарч зорилгоо тайлбарласан тохиолдолд иргэн хүнд	20
6	Зөвхөн удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр жирийн иргэнд	13
7	Иргэн хүн татвар төлөгчийн хувьд	11
8	Хувийн журмаар гуйж, туслалцаа хүссэн тохиолдолд	9

35 байгууллага “төрийн бус болон хувийн байгууллага мэдээлэл авах хүсэлтээ албан ёсоор гаргасан тохиолдолд” мэдээлэл чөлөөтэй олж авах боломжтой гэж хариулсан байна.

Түүнчлэн 20 байгууллага мэдээллийн агуулга, тоо, хэмжээ, багтаамжаас хамаарч зорилгоо тайлбарласан тохиолдолд иргэн хүн мэдээллийг ашиглах, хэрэглэх зорилгоо тайлбарласан нөхцөлд мэдээллийг чөлөөтэй олж авах боломжтой гэдэг нь Мэдээллийн Эрх Чөлөөний хуулийн олон зарчимтай нийцэхгүй.

Судалгаанд хамрагдсан 47 байгууллагуудаас 8 байгууллага мэдээллийг төлбөртэй өгдөг бол бусад байгууллагууд нь аливаа төлбөр, хураамж авдаггүй байна. Харин төлбөр авдаг эдгээр 8 байгууллагууд төлбөр нь үйлчилгээний зардлыг бүрэн нөхөж чаддаггүй гэжээ.

Байгууллагын нууцын тухай хуулиар (1995) байгууллага өөрийн нууц болон нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан.

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудаас 12 нь байгууллагынхаа нууцын жагсаалт, нууцаа хадгалах, хамгаалах журмаа батлаагүй байна. Түүнчлэн зарим байгууллагууд байгууллагынхаа нууцын жагсаалтыг байгууллагын нууцад (23 байгууллага) оруулж байгаа нь буруу юм.

Учир нь байгууллагын нууцын жагсаалт ил тод байвал ямар мэдээлэл нь байгууллагын нууцад орж байгааг хүн бүр мэдэх боломжтой, тиймээс нууцын жагсаалтад орсон мэдээллийг авах хүсэлтийг гаргахгүй.

Харин нууцын жагсаалт нь нууц байвал, эрх бүхий этгээд ямар нэг нэгэн мэдээллийг өгөхгүй байх санаа зоригийн үүднээс тухайн мэдээлэл нь хэдийгээр байгууллагын нууцад хамаарахгүй байсан ч байгуул-

лагын нууц гэсэн үндэслэлээр өгөхөөс татгалзах боломжийг олгох болно. Байгууллагын нууцын жагсаалт нь нууц биш, харин түүнийг хадгалах, хамгаалах журам нь нууц байх нь тохиромжтой юм. Судалгаанд хамрагдсан нийт байгууллагын 14 байгууллага нууцын жагсаалт байгууллагын нууцад ордоггүй гэж хариулжээ. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт ил байдаг.

Мөн байгууллагын нууцын жагсаалт, нууцаа хадгалах, хамгаалах журмаа батлаагүй байгаа баталсан байгууллагууд нь нууцын жагсаалтаа байгууллагын нууцад хамааруулж байгаа нь мэдээлэл чөлөөтэй хүртэх эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг байна.

Төрийн байгууллагын албан хаагч иргэдэд мэ-

	Байгууллагынхаа нууцын жагсаалтыг баталсан эсэх		Байгууллагынхаа нууцыг хадгалах, хамгаалах журам гаргасан эсэх		Байгууллагын нууцын жагсаалт нь байгууллагын нууцад ордог эсэх		Байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах журам нь байгууллагын нууцад хамаардаг эсэх	
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Төрийн байгууллагууд	32	12	33	12	23	14	26	12

дээлэл өгөхдөө даргын зөвшөөрөл авдаг эсэх талаар судалгаанд оролцогчдоос асуулга авсан юм.

Судалгаанд оролцогчдын 30 нь зөвшөөрөл авдаггүй гэж хариулсан бол, 12 нь даргын зөвшөөрөл авдаг гэж хариулсан байна. Хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээллийг авах хүсэлт иргэн хүн гаргасан бол даргын зөвшөөрөл авах шаардлага байхгүй.

Төрийн байгууллагаас иргэд мэдээлэл авах хүсэлт гаргадаг эсэх талаар судалгаанд оролцсон 47 байгууллагын 25 байгууллага “тийм” 14 байгууллага “хааяа” 3 байгууллага “үгүй” гэж хариулсан байдгаас үзэхэд иргэд төрийн байгууллага, албан хаагчдаас мэдээлэл олж авах хүсэлт гаргадаг харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан 47 байгууллагын 17 байгууллага нь 2002 онд иргэдийн гаргасан мэдээлэл авах хүсэлт, хүсэлтэд хариу өгсөн талаар ямар нэгэн тоо, бүртгэлтэй байсан юм.

Бусад байгууллагуудын хувьд мэдээлэл авах хүсэлт гаргасан болон өгсөн хүний талаар бүртгэл, тооцоо байхгүйгээс шалтгаалан энэхүү асуултад хариулах боломжгүй гэх зэргээс хариулсан болно. Жишээ нь: Улсын нийгмийн халамжийн газар иргэд байнга мэдээлэл авч байдаг, тодорхой тоо байхгүй гэж хариулсан. 2002 онд судалгаанд хамрагдсан 17 байгууллагаас мэдээлэл авах хүсэлт 11865 иргэн гаргажээ. Мөн онд

эдгээр байгууллага 35565 иргэнд мэдээлэл өгч, 89 иргэнд мэдээлэл өгөхөөс татгалзсан байна.

Үндэсний статистикийн газар 2002 онд давхардсан тоогоор 441 иргэнд, үүнээс гадна захиалгат буюу төлбөртэй мэдээллийг 864 байгууллагад, төрийн 1654 байгууллага, аймаг, нийслэлийн 108, албан бичгээр 6, гадаадын 100 байгууллагад гэх зэргээр нийт 3173 иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгсөн байна.

Иргэд төрийн байгууллагаас ихэвчлэн ямар төрлийн мэдээлэл авах хүсэлт гаргадаг талаар судлахад дараахь төрлийн мэдээлэл авах хүсэлт гаргасан байна.

Үүнд: шинээр гарсан хууль, тогтоомж, байгууллагын үйл ажиллагаа, бүтцийн талаар, сургалтын төлбөр, түүнээс чөлөөлүүлэхэд баримтлах эрх зүйн акт, тодорхой үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрлийн тухай, гаалийн бүрдүүлэлтийн журам, татварын хувь хэмжээ, банк, банк бус байгууллагын талаар, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой мэдээлэл, хөнгөлөлт үйлчилгээний талаар, цалин, гадаадад ажил эрхлэх, хөдөлмөр эрхлэх талаар, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны өнөөгийн байдал, гэмт хэргийн төрлийн талаарх судалгаа, тодорхой хэргийн шийдвэрлэлт, хорих ял эдлүүлэлтийн байдал, цагдан хорих, хорих үйл ажиллагаанд хүний эрх зөрчигдөж байгаа эсэх, хийхээр төлөвлөж буй ажлын талаар, өмнө ажиллаж байсан хүмүүс лавлагааны материал авах, эрчим хүчний үнэ, өртгийн талаар, цахилгаан

болон дулааны хангамжийн талаар, янз бүрийн норм, норматив, иргэн өөртэйгээ холбоотой иргэний бүртгэлийн мэдээлэл, оюутнуудын диплом болон курсийн ажлын төсөлд зориулсан мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, геодези зураг зүйн материал, газар зохион байгуулалт, төлөвлөгөө, шийдвэр зэрэг мэдээлэл багтдаг байна.

Манай улсад төрийн байгууллага, албан хаагчдаас иргэдийн мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэхэд цаашид юу хийх шаардлагатай байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулжээ:

д/д	Хариултын хувилбар	Төрийн байгууллага /тоо/
1	Эрх зүйн орчин бүрдүүлэх	17
2	Төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байгаа тул иргэдэд энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа сайн хийх	21
3	Төрийн байгууллагын үйл ажиллагааг одоогийн байгаа түвшнөөс илүү ил тод, нээлттэй болгох	17
4	Эрх зүйн зохицуулалт шаардлагагүй, харин зохион байгуулалтын арга хэмжээ авах хэрэгтэй	10

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын 21 байгууллага нь төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байгаа тул иргэдэд энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа сайн хийх хэрэгтэй гэж хариулсан нь төрийн байгууллагууд ил тод, нээлттэй байх чиглэлээр цөөнгүй ажил зохион байгуулж байгааг харуулж буй хэрэг юм. Түүнчлэн энэ асуудлаар иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил дутагдалтай байгааг давхар илтгэж байна. Гэхдээ энэ нь хангалттай бус, цаашид мэдээлэл олж авах эрхийг хангахын тулд

1. Эрх зүйн орчин бүрдүүлэх (17 байгууллага),
2. Төрийн байгууллагын үйл ажиллагааг одоогийн байгаа түвшинөөс илүү ил тод, нээлттэй болгох шаардлагатай (17 байгууллага) гэж хариулжээ.

### Дүгнэж үзвэл:

1. Төрийн байгууллагууд нь байгууллагын үйл ажиллагаа, ажлын үр дүнг олон нийтэд мэдээлэх чиг үүрэг бүхий газар, хэлтэс, албыг судалгаанд хамрагдсан байгууллагын ихэнх нь ажиллуулдаг байна. Мөн төрийн байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийн тогтолцоо нь системтэй, кодлогдсон, эмх цэгц сайтай байна. Мэдээлэл нь ихэвчлэн электрон болон бичмэл, баримт бичгийн хэлбэрээр хадгалагдаж байгаа нь иргэдэд мэдээллээр үйлчлэх үйлчилгээний гол бааз суурь болох мэдээллийн эх сурвалж нь ашиглахад хялбар, зохих түвшинд байгааг харуулж байна.

Гэхдээ эдгээр газар, хэлтэс, алба нь байгууллагын зорилго, зорилт, чиг үүрэг, төсөв, бүтэц, зохион байгуулалт, ажлын үр дүн зэрэг мэдээллийг бус голчлон хурал, уулзалт, семинар зохион байгуулсан тухай мэдээлэл түгээж байгаа нь дутагдалтай байна. Иймд цаашид дээрх газар, хэлтэс, албаны иргэдэд мэдээлэл өгөх үйл ажиллагаа, ажлын үр дүнг олон нийтэд мэдээлэх чиг үүргийг илүү үр дүнтэй болгох нь чухал.

2. Төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар нууцалсан мэдээллээс бусад мэдээллийг нууцлах хандлага төрийн байгууллагуудад байгаа нь иргэдийн мэдээлэл олж авах эрх, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байх, иргэддээ үйлчлэх бодлого хэрэгжихгүй байх нэг шалтгаан юм. Иймд Монгол улсын Үндсэн хууль, төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн зүйл заалтыг зөв ойлгох, тайлбарлах талаар төрийн албан хаагчдад зориулсан сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах шаардлагатай.

3. Судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан зарим байгууллагууд байгууллагын нууцын жагсаалт, нууцаа хадгалах, хамгаалах журам гаргаггүй, мөн зарим нь нууцын жагсаалтаа байгууллагын нууцын жагсаалтад хамруулсан байна. Энэ байдал нь иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хязгаарлаж

байна. Иймд төрийн байгууллагуудад байгууллагынхаа нууцын жагсаалтыг батлах, нууцын жагсаалтыг ил байлгах, нууцаа хадгалах, хамгаалах журмаа нууцлах талаар зөвлөмж, сургалт, сурталчилгааны ажил зохиох хэрэгтэй.

4. Иргэд хуулиар хориглосноос бусад мэдээллийг төрийн байгууллагаас чөлөөтэй олж авах эрхтэй. Харин амьдрал дээр иргэдэд мэдээлэл өгөхдөө даргын зөвшөөрөл авдаг практик байна. Энэ нь буруу бөгөөд ийм практикийг өөрчлөх шаардлагатай байна.

5. Иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хангахын тулд төрийн байгууллагаас хэрхэн мэдээлэл олж авах талаар иргэдэд зориулсан арга хэмжээ явуулах шаардлагатай байна.

## Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын нэрс:

### 1. УИХ-аас байгуулагддаг байгууллага:

1. Монгол банк
2. Төрийн албаны зөвлөл
3. Үндэсний статистикийн газар

### 2. Төрийн захиргааны төв байгууллага:

1. Хууль зүй, дотоод хэргийн яам
2. Гадаад хэргийн яам
3. Санхүү, Эдийн засгийн яам
4. Батлан хамгаалах яам
5. Үйлдвэр худалдааны яам
6. Эрүүл мэндийн яам
7. Дэд бүтцийн яам
8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
9. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

### 3. Шүүх эрх мэдлийн болон бусад байгууллагууд:

1. Нийслэлийн шүүх
2. Сүхбаатар дүүргийн шүүх
3. Улсын Ерөнхий Прокурорын газар
4. Чингэлтэй дүүргийн прокурор
5. Нийслэлийн засаг даргын тамгын газар

6. Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
7. Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар
8. Хан-уул дүүргийн засаг даргын тамгын газар
9. Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар
10. Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс
11. Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтэс

#### 4. Засгийн газрын тохируулагч агентлаг:

1. Тагнуулын ерөнхий газар
2. Цагдаагийн ерөнхий газар
3. Төрийн өмчийн хороо
4. Улсын мэргэжлийн хяналтын газар
5. Хил хамгаалах ерөнхий газар
6. Зэвсэгт хүчний жанжин штабын газар
7. Улсын иргэний хамгаалалтын газар

#### 5. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг:

1. Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
2. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
3. Гал түймэртэй тэмцэх газар
4. Оюуны өмчийн газар
5. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв
6. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
7. Улсын нийгмийн халамжийн газар

8. Гадаадын худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар
9. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар
10. Түлш эрчим хүчний ерөнхий газар
11. Газрын тосны хэрэг эрхлэх газар
12. Авто замын газар
13. Иргэний нисэхийн ерөнхий газар
14. Үндэсний татварын ерөнхий газар
15. Үндэсний архивын газар
16. Улсын нөөцийн газар
17. Гаалийн ерөнхий газар

Нийт 47 байгууллага

## 28. Бусад орон дахь мэдээллийн эрх чөлөөний баталгаа

Одоогоор 52 улс орон Мэдээллийн эрх чөлөөний хуультай байна.

Түүнээс 20 гаруй нь 2000 оноос хойш батлагджээ. Унгар, Латви, Чех, Албани, Гүрж, Болгар, Орос, Украин, Литва, Эстон, Молдав, Словак, Кыргыз зэрэг улс орон мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан хуультай болж олон жилийн өмнөөс ийм хуультай болсон ардчилал хөгжсөн орнуудын эгнээнд нэгдэж чаджээ.

Эдгээр шинэ хууль нь нууцлаг байдал, хаалттай хаалганы цаана авилгал өсөн нэмэгдэж байсан улс орнуудын олон нийтэд мэдээлэл авах боломж олгож өгчээ. Хамгийн гол нь Засгийн Газрын дотоод үйл ажиллагааны талаар мэдээлэл нээлттэй болсон нь маш чухал ач холбогдолтой юм.

Үүний үр дүнд захиргааны байгууллагын үйл явцын талаарх олон нийтийн мэдлэг болон шийдвэр гаргахад иргэдийн оролцоо өсөн нэмэгдэж байна.

Бусад орнуудын мэдээлэл олж авах эрхийн эрх зүйн зохицуулалтын талаар товч танилцуулъя.

## АВСТРИ УЛС

Холбооны хуулинд “Бүх холбоо, муж, орон нутгийн Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болон бүх корпораци нууцыг нь хуулиар хамгаалаагүй тохиолдолд үйл ажиллагааныхаа явцыг ард түмэнд мэдээлж байх ёстой” гэж заажээ. Мэдээллийн Эрх Чөлөөний тухай хуульд мэдээлэлтэй танилцах харилцааг нарийн заасан бөгөөд хүсэлт тавигч мэдээлэлтэй танилцах зөвшөөрөл авч чадаагүй бол Засаг захиргааны шүүхэд хандаж болохоор заасан байна. Нууцыг задруулах, албан бичиг баримтыг мэдээлэх хоёрыг ялган тайлбарласан байдаг. Үүнд, хэрэв төрийн албан хаагч нууцыг задруулсан тохиолдолд тухайн хүн хариуцлага хүлээнэ. Нэгэнт задарсан мэдээллийг сонин хэвлэл нийтлэх эрхтэй байдаг.

## ФИНЛЯНД УЛС

Финляндчууд мэдээллийн эрх чөлөөг эрхэмлэдэг улс орнуудын нэг. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг 1919 онд баталсан.

Энэхүү хуулинд: “Финляндын иргэн бүр ямарваа нэгэн бичвэр материалыг хэрвээ энэ хуулийн зүйл заалтуудтай харшлаагүй бол олон нийтийн удирдлагуудын зүгээс урьдчилсан шалгалт хяналтгүйгээр нийтлүүлэх эрхтэй” гэж заасан байдаг. Мэдээлэлд хүрэх боломжийг 1951 онд батлагдсан “Албан ёсны баримт бичгийг хэвлэх тухай хууль”-иар олгосон юм.

Албан ёсны баримт бичигтэй танилцах боломжийг баталгаажуулж, хүсэлт гаргасан хүмүүст нь тухайн баримтыг нь олгох үүрэгтэй төрийн албан тушаалтан байгууллага бүрт байдаг ажээ. Хэрвээ материал хүсэгч татгалзсан хариу авбал тухайн татгалзсан байгууллагадаа давж заалдах цаашилбал, хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд Дээд шүүхэд давж заалдах эрхтэй юм. Мөрдөн байцаах болон цагдаагийн байгууллагын мэдэлд байгаа хавтаст хэргүүд шүүхэд шилжээгүй бол эдгээрийг олон нийтэд мэдээлэхийг хоригложээ. Мөн “боловсрогдож байгаа” болон дотоод хэрэгцээний баримт бичгүүд, түүнчлэн меморандум /санамж бичиг/ гэх мэт материалууд нууцын зэрэглэлтэй байдаг. Хэрэв олон улсын аюулгүй байдал, гадаад таатай харилцаа, батлан хамгаалахтай холбоотой материалыг шаардлагатай гэж үзвэл нууцлаж болно.

## ФРАНЦ УЛС

---

---

Албаны мэдээлэл авах эрх нь үндсэндээ эрх зүйн гурван актаар зохицуулагдана. Эдгээрээс захиргааны бичиг баримтанд хүрэх тухай 1978 оны тогтоол болон энэхүү тогтоолыг 1979 оны хууль дагалдан үйлчилнэ. Энэ хуулиар захиргааны байгууллагуудаас мэдээлэл олгохоос татгалзах болсон үндэслэлээ гаргаж өгөхийг шаардана. Албаны мэдээллийг зохицуулах гурав дахь эрх зүйн акт болох 1978 оны Мэдээлэл болон Эрх чөлөөний тухай хууль нь компьютер болон хавтаст хэрэгт буй хувь хүний мэдээлэлд нэвтрэх асуудлыг зохицуулна.

Захиргааны мэдээлэлд нэвтрэх тухай хууль тогтоомжууд нь “хүн бүр мэдээлэлд хүрэх” эрхийг бий болгоно. Хуулиар мэдээлэлд нэвтрэх тухай ирүүлсэн гомдлыг шалгах үүрэг бүхий Захиргааны мэдээлэлд нэвтрэх тухай Комисс /CADA/ байдаг. Мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагч эхлээд CADA-тай зөвлөлдөх бөгөөд CADA тухайн байгууллагыг мэдээлэл өгөхийг ятгаж хүсэлт тавьдаг байна. Энэхүү эхний шат амжилтгүй болсон тохиолдолд өргөдөл гаргагч захиргааны шүүхэд ханддаг.

## БЕЛЬГИ УЛС

---

---

1994 оны Үндсэн хуульд “хууль, дүрэм, журмаар ямар нэгэн болзол тавиагүй тохиолдолд хүн бүр засаг захиргааны бүх бичиг баримтыг ашиглаж, хуулбарлаж болно” гэж заасан. Засаг захиргааны нээлттэй байдлын тухай хууль нь “засгийн газрын удирдлагад хамааралтай, аливаа төрлийн, бүх мэдээлэл”-д үйлчилдэг.

Хуулиар удирдлагын тогтолцооны талаар үнэгүй болон төлбөртэй мэдээлэл, зөвлөгөө өгөх үүргийг засгийн газрын болон орон нутгийн удирдлагад даалгасан. Аюулгүй байдал, бусдын эрхийг хамгаалах, олон улсын харилцаа, нийтийн тайван байдал, үндэсний батлан хамгаалах, гэмт хэргийн мөрдлөгийн улмаас мэдээлэл ашиглахыг эсэргүүцэж болно.

Хувийн нууц мөн хуулиар хамгаалагдсан. Бүрэн бус бичиг баримтыг олонд зарлавал буруу ташаа ойлголт өгөх нөхцөлд тэдгээрийг нууцална. Мэдээлэл авах хүсэлт гаргагчийн хүсэлт няцаагдвал Засаг Захиргааны Бичиг Баримттай Танилцах Комиссыг өргөдөл гаргаж дахин хянаж үзэх санаа тавих бөгөөд энэ асуудал шийдэгдэхгүй бол шүүхэд шилжүүлдэг байна.

## ДАНИ УЛС

Европын хэмжүүрээр Дани улс хамгийн нээлттэй оронд тооцогдсоор байна. Гэвч Данийн сэтгүүлчид Засгийн газрынхаа болон хууль шүүхийн байгууллагуудын нээлттэй байдлын тухай үзэлд нь нэлээд шүүмжлэлтэй хандсаар байгаа билээ. 1987 онд Олон Нийтийн Удирдлагын Баримт Бичигтэй танилцах тухай хуультай болсон. Бүх яамд, газар, хэлтэс болон орон нутгийн удирдлагын байгууллагууд, олон нийтийн байгууллага, компани, аж ахуйн нэгжийг бүртгэдэг газрууд энэхүү хуулинд хамрагддаг байна.

Сэтгүүлчид уг хуулийн дагуу дээр дурьдсан аль ч байгууллагаас мэдээлэл, баримт хүсэх эрхтэй бөгөөд хэрэв хүссэн материалын зарим хэсгийг ямарваа нэгэн шалтгаанаар хаан дарагдуулахыг оролдвол тэр үлдсэн хэсгийг ч мөн олон нийтэд ил тод болгох эрхтэй ажээ. Мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд мэдээлэл хүсэгч нь шүүхэд хандах эрхтэй. Зарим тохиолдолд иймэрхүү хэргүүдийг Парламентын Омбудсмен шийддэг. Дани Улс Нууцлалын тухай албан ёсны хуульгүй юм. Тэгэхдээ мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжид энэ асуудлын тухай тусгасан нь их байдаг. Хэрвээ аливаа нэгэн нууц материал ил болсон бол түүнийг хэвлэн нийтлэх нь хууль зөрчсөн хэрэг биш болдог. Гэхдээ хэрэв энэхүү материал нь улсын аюулгүй байдалд хамаарахгүй тохиолдолд.

## ГОЛЛАНД УЛС

Голландад мэдээлэл олж авах эрхийг хуулиар баталгаажуулсан. Голландын Үндсэн хуульд Засгийн Газрын байгууллагууд өөрсдийн хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхдээ Парламентын тухай хуулийн заалтуудтай уялдуулан олон нийтийг мэдээлэл олж авах эрхийг хангах ёстой хэмээн заажээ. Мөн түүнчлэн Үндсэн Хуульд мэдээллийг цензурдах болон хориглох тухай асуудлын эсрэг хатуу заалтууд байдаг. Мөн хуулийн 7-р зүйлд “Хуулийн дагуу хүн бүхний хүлээх үүрэг хариуцлагыг урьдчилан цензурдалгүйгээр тэдний бодол санаагаа хэвлэлийн хэрэгслээр дамжуулан илэрхийлэхэд хэн нэгэн нь урьдчилан зөвшөөрөл шаардах ёсгүй” гэж заажээ.

1978 онд гарсан Олон нийт мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийг нэрийг нь өөрчлөлгүйгээр 1992 онд шинэчлэн батлан мөрдөж байна.

Тус хууль нь яамдууд, орон нутгийн эрх барих дээд байгууллагууд, хотын захиргаад, ус зохицуулалтын газар болон аж үйлдвэрийн салбарын зохицуулагч байгууллагууд өөрсдийн салбарын хүрээнд засгийн газраас зааж өгсний дагуу эрэмблэгдсэн, компьютерт бичигдсэн болон хэвлэмэл мэдээллийн талаар асуудлыг мөн уг хуульд зааж өгсөн.

Бусад улс орон, олон улсын байгууллагатай харилцах харилцаа, олон улсын байгууллагуудын эдийн засгийн ашиг сонирхол, гэмт хэргийн мөрдөн байцаалт, ялын дээд хэмжээний гүйцэтгэл, хувийн нууцтай холбоотой баримт материалуудад харьцангуй хязгаарлалт байдаг байна.

Эдгээр асуудлаар мэдээллийг олж авахын тулд хүсэлт гаргагч нь мэдээллийг олон нийтэд ил тод болгох нь учруулах хор хохирлоос хир зэрэг ач холбогдолтой байж болохыг нотлох шаардлагатай байдаг.

Мэдээлэл авахыг хүссэн өргөдөл нь татгалзсан хариу авсан тохиолдолд шүүхэд хандана.

Захиргааны шүүхээр орсон бүх хэрэгт мэдээллийг ил болгохыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж байжээ.

## ШВЕД УЛС

Хэвлэлийн эрх чөлөөг дээдэлж, албан баримт материалуудтай танилцах эрх нь хангагдсан байдаг учраас Швед улс дэлхий дээр нээлттэй орны тоонд ордог. 1949 оноос хойш Шведийн Засгийн газрын нээлттэй байх явдал байсаар иржээ.

Нээлттэй байх зарчим бол Шведийн Үндсэн хуулийн үндсэн хэсэг байдаг. Засгийн газрын тухай хууль /1974/, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль /1949/, Үг хэлэх эрх чөлөөний тухай хууль гэсэн 3 хууль нь Шведийн үндсэн хуулийн бүрдэл хэсэг болдог байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө өөрөөр хэлбэл мэдээлэл дамжуулах эрх чөлөө, үзэл бодол, бодол санаа, сэтгэлийн хөөрлөө амаар бичгээр үйл хөдөлгөөнөөр болон бусад арга хэлбэрээр илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө өөрөөр хэлбэл мэдээлэл олж авах, хүлээж авах, бусдын хэлсэн ярьсан зүйлтэй танилцах эрх чөлөөг Засгийн Газрын тухай хуулиар бүх иргэдэд баталгаажуулсан байна. Засгийн газрын тухай хуулиар олгогдсон эрхийг зөвхөн аливаа ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хязгаарлаж болно. Онцгой шалтгаан байхгүй бол хүссэн мэдээллийг заасан хугацаанд өгөх ёстой байдаг.

Мэдээлэл авахыг хүсээд татгалзсан хариу авсан хэн болгон захиргааны шүүхийн байгууллага, цаашлаад захиргааны дээд шүүхэд зарга мэдүүлэх эрхтэй байдаг.

Мэдээлэл олж авах эрхтэй холбоотой нэмэлт хамгаалалтыг энэ төрлийн маргаанд оролцох эрхтэй Омбудсмены шүүх /парламентын/ байгууллага олгодог.

## Мэдээллийн эрх чөлөөний хуулийн үр нөлөө, амжилт

Иргэд мэдэх эрхээ эдлэх нь төрийн албан тушаалтнууд үйл ажиллагаагаа илүү нээлттэй байдлаар явуулахад нь нөлөөлдөг.

- 2003 онд Мексикийн Мэдээллийн эрх чөлөөний хуульд түүнд заасан бүх байгууллагууд нарийвчилсан төсвөө багтаасан тодорхой мэдээллүүдийг хэвлэн нийтэлж байх зохицуулалт оржээ.

Энэ хуульд заасан байгууллагын нэг нь олон нийтийн санхүүжилт бүхий Үндэсний Политехникийн Институт /Instituto Politecnico Nacional/ байдаг. 2003 оны 9-р сард, Үндэсний Политехникийн Институт цалингийн цэсээ олон нийтэд нээлттэй болгосноор сарын 60.832 Мексик песо /6000 орчим ам доллар/-гийн үндсэн цалинтай нэгэн профессор жил бүр 782.502 Мексик песо /78000 ам доллар/-ийг нөхөн төлбөрт хууль бусаар авч байсан нь илэрсэн байна.

Бас нэгэн дунд тушаалын ажил олгогч 567855 Мексик песо /57000 ам доллар/ буюу албан тушаалын цалингаа 10 дахин нугалсантай тэнцэхүйц хэмжээний мөнгө авсан байв.

Захирал нь ажилчдынхаа үндсэн цалинг байнга хэтрүүлдэг мөн ямар нэг үндэслэлгүйгээр шагнах асуудлаар хүний нөөцийн даргад захидал илгээсэн байсныг байгууллагын архиваас нь илрүүлсэн байна. Жишээ нь, олон нийттэй харилцах албаны захиралд түүний үндсэн цалин дээр нь нэмж 254358 Мексик песо /25000 ам доллар/-ыг шагнал болгож өгсөн байв.

Ингэж нэмж өсгөсөн цалингууд нь Үндэсний Политехникийн Институтийн төсөвт бараа, ажил үйлчилгээний сэжиг бүхий өндөр зарцуулалтаар илэрсэн байна. Жишээ нь, “багц”-ад зарцуулах төсвийн нэг үзүүлэлтэд нь нийт 4 сая песо /400000 ам доллар/ болж байв.

Шалгалтын явцад Үндэсний Политехникийн Институтийн шинэ захирлыг зөвхөн зөрчил гаргагч гэдэгт нь бус, магадгүй олон нийтийн санхүүжилтээс 2003 онд 400 сая песо буюу 40 сая ам долларын хадгаламжтай байсан нь ажлаас халах чухал үндэслэл болсон байна.

Мексикт одоо олон нийт, идэвхтэй иргэд иймэрхүү нарийн хяналт дор бусад олон нийтийн боловсролын байгууллагуудын данс тооцоог нээлттэй болгох ёстой гэж шахаж шаардаж эхэлжээ.

Японы зарим хуульчид нь орон нутгийн захиргааны түвшинд мэдээлэл олж авах хуулийг орон нутгийн захиргааны албан тушаалтнуудын зардлын тайланг ил болгоход ашиглажээ.

Ингэснээр пиво, саки ууж зугаацахаас аваад хүнд сурталтан зочдоо томоохон ресторанд дайлж цайлж, их хэмжээний мөнгө зарцуулсныг илрүүлж чадсан байна.

Үүний үр дүнд Японы 47 мужууд хоол хүнс, ундааны төсвөө 100 сая ам.доллараас илүү гарсныг тэнцүүлж хассан байна.

## Иргэний нийгэм МЭЧ-ний хуулийг ашигладаг

Мэдээллийн эрх чөлөөний хуулийг баталгаажуулахад иргэний нийгмийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэдэг.

Ялангуяа Зүүн Европ, Латин Америк, Африк, Азийн ардчилал шилжилтийн үедээ яваа улс орнуудад иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэгтэй байна.

ИНБ-ууд нь парламентад лоббидох, хуулийн төслийг олон нийтэд таниулах, олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх кампанит ажил зохиох, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулах, шинэ хуулийг батлан гаргахад нөлөөлж засгийн газарт шахалт үзүүлдэг.

Ингэж энэ хууль нь ардчилсан үйл явцын үр дүн болж ирсэн юм.

Одоо МЭЧ-ний хуулийг баталгаажуулах хөдөлгөөний ард байсан ИНБ-ууд одоо мэдээлэл авах хүсэлтийг биелүүлэх, түүний хэрэгжилтийг дэмжих талаар идэвхтэй ажиллаж, мэдээллээр хангахаас татгалзсан маргаантай асуудлаар шаардлагатай бол шүүхэд хандаж ажиллаж байна. Жишээлбэл:

- “Мэдээлэл Олж Авах Хөтөлбөр /AIP/” нэртэй

Болгарын ТББ нь эрх зүйн зөвлөгөө өгөх болон авилгалын эсрэг бүлэглэлүүд зэрэг өргөн хүрээний байгууллагуудыг дэмжиж ажилладаг.

AIP нь олон нийтэд болон Болгарын Мэдээлэл олж авах эрхийн хуулийг ашиглаж авилгалыг илрүүлэх чиглэлээр ажилладаг зарим байгууллага, гишүүдэд эрх зүйн туслалцаа үзүүлж утсан холбоо ажиллуулдаг.

Тус байгууллагаас зөвлөгөө авсан иргэдийн нэг Ивайлд Ганчев 2003 оны эхээр Шинжлэх ухаан боловсролын ямаар явж байхдаа үүдний өрөөнд нь хувийн компани зар сурталчилгаагаа тавьж үзүүлж байсныг харжээ. Тус төрийн байгууллагын байрыг хувийн арилжааны зорилгоор ашиглаж байгаа байдал яамны сайд болон тэр компани хооронд ямар нэг холбоо сүлбээ байгаа байх гэсэн сэжиг түүнд төрсөн байна. Ингээд Ивайлд Ганчев үүдний өөрөөний түрээсийн талаар мэдээлэл авахаар хүсэлтээ яаманд гаргасан байна.

Яам түүнд мэдээлэл өгөхөөс татгалзсан учраас тэр хууль зүйн туслалцаа авахаар AIP-д хандсан байна. Тэд захиргаанд нь давж заалдсанаар хариу авч чадсан ч холбогдолтой бичиг баримт нь тус яаманд одоо байхгүй, улсын архивт шилжсэн учраас энэ талаар мэдээлэл өгч чадахгүй байна гэсэн хариу авсан байна.

AIP Шинжлэх ухаан боловсролын яамнаас хүлээж авсан мэдээллийг авах талаар хүсэлт гаргаж, Улсын

архивын захиралд хандсан байна.

Архив түүнд тус яамнаас хамгийн сүүлд 1991 онд мэдээлэл өгч байсан тухай хариу өгчээ. Ингэж худал ярьж байсан мэдээллийг шүүхэд дэлгэхэд яамны хуульч үүдний өрөөг хувийн компанид түрээслүүлэх талаар ямар нэг гэрээ хийгдээгүй болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

Хэдийгээр, албан тушаалтны буруутай үйл ажиллагааг нээн илрүүлж чадсан энэ хэрэгт зохих албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хянан шийдвэрлэх ажиллагааг явагдаагүй ч иргэний нийгэм авилгал гарч болох боломжийг багасгаж төр засгийг хариуцлагатай байлгаж чадах сайн жишээ болсон гэж үздэг.

Харин олон нийтийн санаа бодол хүчтэй нөлөө үзүүлж чаддаг ардчилал хөгжсөн орнуудад иймэрхүү шуугиан тарьсан мэдээлэл нь шууд албан хаагчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхөд хүргэдэг.

Саяхны нэг жишээ дурдая. Иргэдийн бүлэг мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийг хэрэглэж шинэ бууны бүртгэл хийдэг байгууллагын даргын зарцуулалтын тайланг олж авснаар түүнийг албан тушаалаас нь огцруулахад хүргэж чаджээ.

Тэр дарга Канадын нэг талд байдаг /Едмонтон/ өөрийн гэрээс нөгөө хэсэгт байдаг /Оттава/ ажлын

газар уруугаа нисэж очих 56 ш тасалбартаа 205 мянган ам. долларыг олон нийтийн санхүүжилтаас зарцуулсан нь тайланд бичигдсэн байв.

Мөн 1980 онд Канадын нэг сэтгүүлч Мэдээлэл олж авах хуулийг хэрэглэснээр нэгэн яамны сайд Парист болсон нэг цаг үргэлжлэх хуралдаанд оролцохдоо тэнд улсын зардлаар 5 хоног байсныг илрүүлж сайдыг албан тушаалаас нь огцруулахад хүргэсэн байна.

Иймэрхүү мэдээллийг иргэдийн хяналтын байгууллагууд олж илрүүлснээр албан тушаалаа хэтрүүлэн ашигладаг байдлыг өөгшүүлэхгүй байх чухал механизм болж улс төрчидтэй хариуцлага тооцох бас нэг боломж болдог юм.<sup>1</sup>

---

<sup>1</sup>(Хелен Дарбишере “Мэдээллийн Эрх Чөлөө шударга Засгийн газрыг дэмждэг” нийтлэлээс орчуулав. “Орон Нутгийн Удирдлага” сэтгүүл, Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Будапешт )

## Ашигласан материал

## Олон улсын гэрээ, хэм хэмжээ

1. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1948 он
2. Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт, 1966 он
3. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн анхдугаар чуулга уулзалтын тогтоол, № 59, 1946
4. Олон нийтийн мэдэх эрх. Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зарчмууд, 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
5. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн загвар, 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
6. Мэдээлэл олж авах тухай хуулийн төсөл боловсруулах нь. Төв болон Зүүн Европ, ТУХН-ын орнуудын чиг хандлага, 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
7. Йоханнесбургийн зарчмууд, Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж, 1995, 19-р зүйл байгууллага, Цагдан хяналтын эсрэг олон улсын төв
8. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих олон улсын механизмууд, НҮБ-ын тусгай элч, Европын Аюулгүй Байдлын Байгууллагын (OSCE) эрх чөлөөний төлөөлөгч, Америкийн Улсуудын Байгууллагын (OAS) эрх чөлөөний тусгай элч нарын Хамтарсан тунхаглал, 2000 он

## Үндэсний хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн Хууль, (1992.01.13, ТМ-92 №1)
2. Улсын Их Хурлын дэгийн тухай Монгол Улсын хууль,
3. Төрийн нууцын тухай Монгол Улсын хууль, (1995.04.18, ТМ-95 №7)
4. Төрийн нууцын жагсаалтын тухай Монгол Улсын хууль, (2004.01.02)
5. Байгууллагын нууцын тухай Монгол Улсын хууль, (1995.05.16, ТМ-95 №7)

6. Хувь хүний нууцын тухай Монгол Улсын хууль, (1995.04.21, ТМ-95 №7)
7. Засгийн газрын тухай Монгол Улсын хууль, (1993.05.06, ТМ-93 №3)
8. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль, (1995.04.17, ТМ-95 №7)
9. Авилгалын эсрэг Монгол Улсын хууль, (1996.04.05, ТМ-96 №6)
10. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, (1992.05.08, ТМ-92 №3)

### Бусад:

1. Монгол Улсын Үндсэн Хуулийн тайлбар,
2. Монгол Улс шилжилтийн үед. Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ, 19-р зүйл байгууллага, “Глоб Интернэшнл” ТББ, 2001
3. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, “Сэтгүүлч ба хууль” цуврал № 03, “Глоб Интернэшнл” ТББ, 2001
4. Марк Гармбергер. “Иргэн түншлэгч болох нь” гарын авлага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, 2001
5. Е.Янг, Л.Квин “Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь”, Нээлттэй нийгэм хүрээлэн, 2002
6. Ардчиллыг бүх нийтэд, МННХ, 2000
7. How to use the Access to Public Information Law., citizen`s guide of Bulgaria, September, 2000